

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2016 оны 02 дугаар
сарын 13 -ны өдөр

Дугаар А48/1412

Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.4 дэхь хэсгийг үндэслэн ТУШААЖ, ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөвсгөл аймгийн “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, Мөрөн сумын Засаг дарга /Ц.Гансүх нарт/-д тус тус үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД



Н.БАТЦЭРЭГ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал
жуулчлалын сайдын 2016 оны 02 сарын
28 ны өдрийн А/47 дугаар тушаал,
Аймгийн Засаг даргын 2015 оны 12
дугаар сарын 17-ны өдрийн А/412 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

МӨРӨН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мөрөн сумын хязгаарлалтын бүсд оршин сууж байгаа иргэд, үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд агаарт үзүүлж буй нөлөөллөөс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн хэрэгцээндээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Журмыг Мөрөн сумын Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар шууд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.

1.3. Агаарын чанарын төлөв байдлаас хамааран журамд зохих өөрчлөлт оруулж болно.

1.4. Журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.4.1. "Агаарын чанарыг сайжруулах бүс" гэж агаарын бохирдлыг бууруулах зорилгоор тогтоосон бүсийн хил хязгаарыг.

1.4.2. "Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн" гэж Монгол Улсын болон олон улсын стандарт, норм шаардлагад нийцсэн сайжруулсан зуух, сайжруулсан түлш болон сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, газрын гүний дулаан), биотүлш (ургамал, амьтны гаралтай тосноос гарган авсан шингэн), цахилгаан, бүх төрлийн хийн халаагуурыг;

1.4.3. "Сайжруулсан зуух" гэж "Орон сууцны хатуу түлшээр ажилладаг зуух-Тавигдах шаардлага ба турших аргачилал" MNS EN 13240:2011 болон "Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS 5457-2005 стандартуудыг нэгэн зэрэг хангасан зуухыг;

1.4.4. "Сайжруулсан түлш" гэж Монгол Улсын "Шахмал түлш. Техникийн шаардлага" MNS 5679:2011 стандартын шаардлага хангасан Нүүрсэн шахмал түлш, Хагас коксон шахмал түлш, Модны үртсэн шахмал түлшийг;

Хоёр. Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм

2.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах дэглэмийг мөрдөнө:

2.1.1. Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэх;

2.1.2. Дулаан алдагдлыг багасгах зориулалттай стандартад нийцсэн нэмэлт дулаалга хэрэглэх;

2.1.3. Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж суурьлуулах;

2.1.4. Сайжруулсан зуухнаас бусад зуухыг ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэхгүй байх;

2.1.5. Сайжруулсан түлшнээс бусад зориулалтын бус түлш хэрэглэхгүй байх;

2.1.6. Агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи, тоног төхөөрөмж ашиглахгүй байх;

2.1.7. Хөнгөлттэй үнээр худалдан авсан сайжруулсан зуух болон бусад бүтээгдэхүүнийг бусдад шилжүүлэхгүй, зарж борлуулахгүй байх;

2.1.8. Орон нутаг дахь салбарын дүгнэлтгүйгээр бохирдуулах бодис гаргадаг, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг агаарын бохирдлын эх үүсвэр ашиглахгүй байх;

2.1.9. Стандартын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл хэрэглэхгүй байх;

Гурав. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, мэдээллийн санг хөтлөх;

3.2. Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа айл өрхөд жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд шөнийн хэрэглээний цахилгаан, эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулах;

3.3. Албан татвар төлөгч иргэн өөрийн хэрэгцээнд зориулан стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдан авсан нь баримтаар нотлогдож байгаа бол нотлогдсон төлбөрийн хэмжээтэй тэнцэх орлогыг [1] Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.15.-д заасны дагуу татвараас чөлөөлөх;

3.4. Аж ахуйн нэгж, байгууллага Засгийн газраас тогтоосон жагсаалтад заасан стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан авсан бол тухайн бүтээгдэхүүний үнийн дүнтэй тэнцэх орлогыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн [2] 18.4-д заасны дагуу татвараас чөлөөлөх;

3.5. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн аливаа хэрэглээ, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;

3.6. Агаарын бохирдлын эх үүсвэр, сөрөг үр дагавар, агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, бүтээгдэхүүний ач холбогдол, ахуйн хэрэглээнд шатдаг хий ашиглах, аюулгүй ажиллагааны талаар сургалт, сурталчилгаа явуулах;

Дөрөв. Оролцогч талуудын эрх, үүрэг

4.1.Төрийн байгууллагын эрх, үүрэг:

4.1.1. Мөрөн сумын Засаг дарга болон аймгийн Засаг даргын дэргэдэх Агаарын бохирдлыг бууруулах салбар хороо энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулна.

4.1.2. Баг, хорооны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар агаарын чанарын сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

4.1.3. Баг, хорооны Засаг дарга агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, бүртгэлийн мэдээллээ жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Агаарын бохирдлыг бууруулах салбар хороонд хүргүүлнэ.

4.1.4. УЦУОШАлба агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн санг хөтлөн явуулна.

4.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх,үүрэг:

4.2.1. Энэ журмын 2.1-т заасан дэглэмийг мөрдөх;

4.2.2. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгаанд оролцох;

4.2.3. Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаар харъяалах сум, баг хорооны Засаг даргад мэдээллэх;

4.2.4. Жилд 2 удаа халаалтын улирал эхлэхээс өмнө болон халаалтын улиралд яндангаа тогтмол цэвэрлэж байх;

4.2.5. Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хөнгөлттэй үнээр худалдан авсан бол гэрээний үүргээ биелүүлэх.

Тав .Хариуцлага

5.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд "Агаарын тухай" хуулийн 31.1.3 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Сайжруулсан зуух хөнгөлөлттэй үнээр худалдан авсан эзэмшигч нь зуухаа бусдад шилжүүлсэн, худалдсан бол үндсэн үнээр нь төлүүлнэ.